

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТЭД 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

Нэг. Хяналт-шинжилгээний зорилго

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Барилга, хот байгуулалтын яамны хийж гүйцэтгэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлагыг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Гүйцэтгэлийн түвшинг үнэлсэн байдал

Тус ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

Гурав. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн байдал

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 2019 оны тайлант хугацаанд нийт 59 зорилтын хүрээнд 150 арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажилласан байна. Үүнээс Барилга хот байгуулалтын яам дангаараа хариуцан хэрэгжүүлэх 99, хамтарч хэрэгжүүлэх 51 арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар **94.5** хувьтай байна.

Төлөвлөсөн арга хэмжээний биелэлт яамны дүн

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	Нийт арга хэмжээний тоо	Үүнээс					Хэрэгжилтийн түвшингийн дундаж үнэлгээ /%/
			100%	70%	40%	0%	Үнэлэх боломжгүй	
1	Үндсэн хэрэгжүүлэгч	99	77	14	1	-	7	94.7
2	Хамтран хэрэгжүүлэгч	51	38	7	1	-	5	94.1
	ЗГҮАХХАХТ-д туссан арга хэмжээний дундаж дүн	150	115	21	2	-	12	94.5

НЭГ:

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдээс тайлант хугацаанд зорилтод түвшиндээ хүрч хэрэгжүүлсэн дараах ажлууд байна. Үүнд:

1. "150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн

газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг БХБС-ын 2019 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 125 дугаар тушаалаар батлуулж, албан бичгээр холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн судалгааг аймаг, орон нутгаас гаргуулан авч нэгтгэн боловсруулж, гарын авлага болгон хэвлүүлэхээр бэлэн болгосон. /2.77.1./

2. “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийг хэрэгжүүлэх хэлэлцээрт БХБЯ-ын Төрийн нарийн бичгийн дарга, БНХАУ-ын Буцалтгүй тусламжийн албаны дарга нар гарын үсэг зурж баталгаажуулсан. Зураг төслийн “Интеллект тауер” ХХК 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр зураг төслийг боловсруулан дуусгаж БХБЯ-нд хүлээлгэн өгсөн. Барилгын зураг төслийн дагуу нийт 132.01 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэхээр тусгагдсан бөгөөд барилгын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах Тендерийн баримт бичгийг боловсруулж дууссан. /2.77.4./

3. Барилгын тухай хууль”, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо”-г боловсронгуй болгох ажлын техникийн даалгаврыг боловсруулж, Засгийн газрын гишүүд, төрийн бус байгууллагуудаас санал авч тусган ЗГХЭГ-т 2019.03.05-ны өдрийн 01/774 албан тоотоор хүргүүлсэн. Төслийг Засгийн Газрын 2019.03.21-ний хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн бөгөөд Засгийн газрын 106 дугаар тогтоолоор батлуулаад байна. /2.78.1/

4. Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Стандартын улсын үзлэгийн дүн, холбогдох бодлогын баримт бичгүүдэд үндэслэн боловсруулж Сангийн удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 19-ны хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Төлөвлөгөөнд нийт 110 норм, нормативын баримт бичиг шинээр болон шинэчлэн боловсруулахаар тусгасан, үүнд: техникийн зохицуулалт- 3, барилгын норм ба дүрэм - 32, барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал - 53, стандарт - 22; тус сангаас нийт 2,427,900,932 төгрөгийг зарцуулахаар батлуулсан. /2.78.2/

5. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах зөвлөх үйлчилгээний 119 тоот гэрээг 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-тай байгуулан, төслийн судалгааны ажил болон төсөл боловсруулах ажлыг 2019 онд улсын төсвийн 600,0 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгүүлж байна. Тухайн сум, суурин газар бүрт холбогдох барилга, байгууламж, хот байгуулалтын дэд бүтцийн талаар фото зураг аван бичлэг хийж, ажиглалтын болон баримтжуулах судалгааг Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 70 хувьд хийж гүйцэтгэсэн. /2.79.1/

6. “Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим систем байгуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр эцсийн шатны тайланг хүлээн авсан. /2.81.12/

7. Нийтийн зориулалттай орон сууцанд суурилуулсан ашиглалт, эдэлгээний хугацаа дууссан лифтийг шинэчлэх ажлыг хэрэгжүүлэхээр судалгааны ажлыг хийж дуусгасан. 2019 оны төсөвт 1.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий 15 байрны лифтийг шинэчлэхээр

тусгаснаас 700 сая төгрөгийг тусгуулж Сонгино хайрхан дүүрэгт 9 лифт шинэчилсэн. /2.85.5./

8. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2019.05.06-ны өдрийн 01/1607 тоот албан бичгээр хүргүүлж, уг төлөвлөгөөг Ерөнхий сайдын захирамжаар батлуулах ажлыг зохион байгуулж байна. 2017-2019 онд Орхон, Төв, Дундговь, Завхан, Дорнод, Увс, Хөвсгөл, Өмнөговь, Говьсүмбэр аймгуудын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулж, батлуулсан. /5.2.4.4./

9. Барилга, хот байгуулалтын яам болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас санаачлан Монгол улсад анх удаа харааны бэрхшээлтэй хүүхэд багачууд, сурагчдад зориулсан 4 төрлийн брайль газрын зургийг/ дэлхийн газрын зураг, Монгол орны засаг захиргааны зураг, 116-р сургууль орчмын тойм зураг, сургуулийн хашаан доторх тойм зураг гэсэн төрлөөр/ зохион хэвлүүлж 2019 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар тусгай дунд сургуульд хүлээлгэн өгч суралцах орчныг бүрдүүлж, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн /33.29.1/- зэрэг ажлууд байна.

2. Дараах ажлуудын хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

1. /2.11.3/ Замын-Үүд чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, улмаар Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх /ХБГХБХЗГ, ИДБХЗГ/

2. /4.2.3.3./ Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх / НААБХЗГ/- зэрэг ажлууд байна.

Мөн дараах ажлуудын биелэлтийг үнэлэх боломжгүй байна. Үүнд:

1. /2.79.3/ "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлан, хэрэгжилтийг зохион байгуулах. /ХБГХБХЗГ/
2. /2.80.4/ Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан Газар чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах. /ХБГХБХЗГ/
3. /2.81.2/ Монгол Улс, ОХУ-ын хоорондох хилийн цэсийг тодотгож, баталгаажуулах ажлыг зохион байгуулах. /ХБГХБХЗГ/
4. /2.81.7/ Өндрийн II ангийн сүлжээний давтан хэмжилт хийх ажлын хүрээнд Төв болон Говийн бүсийн нутаг дэвсгэрийн 10537 км шугамын дагуу II ангийн сүлжээг шинэчлэх. /ХБГХБХЗГ/
5. /2.81.8/ Монгол Улсын геодезийн сүлжээний эхлэл цэгийг байгуулах. /ХБГХБХЗГ/
6. /2.81.11/ Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд Улсын хэмжээний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн стратегийг боловсруулж, техник хангамжийг шийдвэрлэх. /ХБГХБХЗГ/
7. /2.94.1/ "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан "Туул усан цогцолбор" барих төслийн зураг төсөв, "Туулын шугуй цогцолбор-зураг

төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулах төсөл”, “Туул, Сэлбэ голын орчныг сэргээн сайжруулах төсөл” зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлыг НЗДТГ-тай хамтран боловсруулж, батлуулах. /ХБГХБХЗГ, БТГ/

8. /3.1.4.8/ Эрүүл мэндийн байгууллагуудын агааржуулалтын системийг шат дараатайгаар шинэчлэн сайжруулах. /ББМБХЗГ/
9. /3.1.15.11/ Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын барилгын өргөтгөлийг барих. /ББМБХЗГ/
- 10./3.2.40.4/ Хиймэл дагуулын хяналтын газрын станцын барилга барих. /ББМБХЗГ/
- 11./4.2.6.2/ Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх. /ХБГХБХЗГ, БТГ/
- 12./5.2.4.6/ Байрлалд суурилсан нийгэм, эдийн засгийн нэгдсэн мэдээллийн сан, системийг улсын хэмжээнд бий болгож, эрүүл мэнд, боловсрол болон бусад байгууллагуудыг ашиглах боломжоор хангаж, тогтолцоог бүрдүүлэх

Дүгнэлт:

1. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Барилга, хот байгуулалтын яамны хийж гүйцэтгэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд гүйцэтгэлийн үнэлгээ **94.5** хувьтай байна.

Санал, зөвлөмж:

1. Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллах;
2. Хөтөлбөрийн биелэлтийг хүрсэн түвшин, цаг хугацаа, зарцуулсан хөрөнгө, шалгуур үзүүлэлт бүрээр мэргэжлийн үг хэллэгээр тайлагнаж хэвших.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР